

Эрүүл
мэндийг дэмжигч

МОНОС
ХҮНС

ХАГАС ЖИЛИЙН **2019**
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

КОМПАНИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компанийн ерөнхий танилцуулга, бүтэц
Бүтээгдэхүүний танилцуулга
Онцлох үйл явдлууд

УДИРДЛАГЫН БАГ

Төлөөлөн удирдах зөвлөл
Гүйцэтгэх удирдлага

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Санхүүгийн тайлан
Орлого, үр дүнгийн тайлан

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ


Хувьцаа эзэмшигчдийн хурал
Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид
Хувьцааны мэдээлэл

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

КОМПАНИЙН БИЗНЕСИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА

МОНОС ХҮНС ХК нь Монгол улсын эмийн салбарт манлайлагч Монос Группийн отгон компаниудын нэг бөгөөд эрүүл мэндийг дэмжсэн хүнс болон хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл худалдааны чиглэлээр 2012 оноос үйл ажиллагаа явуулж байгаа үндэсний үйлвэрлэгч компани юм. Анх 3 брэндийн 13 нэр төрлийн бүтээгдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол 2019 оны эхний хагас жилийн байдлаар 134 үндсэн ажилтантай, 6 брэндийн 82 нэр төрлийн бүтээгдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ





АЛСЫН ХАРАА

Эрүүл мэндийг дэмжсэн органик хүнсний бүтээгдэхүүнийг өдөр тутмын хэрэглээнд хэвшүүлэх.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрүүл мэндийг дэмжсэн хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн сэтгэл ханамжид нийцүүлэн, олон улсын стандартаар үйлдвэрлэгч, экспортологч, дотоодын зах зээлд тэргүүлэгч компани байх



ҮНЭТ ЗҮЙЛ

- Эрхэм хэрэглэгч
- Эрүүл чанартай бүтээгдэхүүн
- Итгэлтэй харилцагч
- Ёс зүйтэй бизнес
- Мэдлэг, чадвартай бүтээлч хамт олон
- Шинэ санал, санаачилга

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

ЦЭНЭГ



Насанд хүрсэн хүний нэг өдрийн тунгаар савлагдсан 7 төрөл, 24 SKU* бүхий эрүүл мэндийн бэлдмэл.

ЭНХЖИН



Эм судлалын хүрээлэнгийн эрдэмтдийн олон жилийн судалгаа шинжилгээний үндсэн дээр бүтээгдсэн, эмийн ургамалтай эрүүл мэндийн цуврал цай. 13 SKU*.

ХААН ЖИМС



Дархан-Уул аймгийн "Бүрэн толгой" н үржил шимт хөрсөнд тарьж ургуулсан чацаргана жимсээр хийсэн 5 SKU* бүтээгдэхүүн.

БЕРРИВИТ



Хүүхэд багачуудын хамгийн дуртай ааруултай, үзэмтэй, витаминт гасан 3 нэр төрлийн 16 SKU* бүтээгдэхүүн.

ЭКО УУСДАГ ЦАЙ



Импортын орлох үндэсний брэнд, байгалийн зэргэл жимс, үр тариатай Монголын анхны уусдаг цай. 12 SKU*.

ЭКОС



Биеийн хүчил шүлтийг тэнцвэржүүлэх, хужраар эрдэсжүүлсэн эрүүл мэндийн зөөлөн ус. 2 SKU*.

ӨТГӨРҮҮЛСЭН БАРАГШУН



Монгол орны охь болсон түүхий эдийг дэвшилтэт технологиор боловсруулж, хэрэглэхэд хялбарар савласан ӨТГӨРҮҮЛСЭН БАРАГШУН бүтээгдэхүүн.

ШИДЭТ САРИМС



"Шидэт саримс" нь эх орны хөрсөнд ургасан саримсыг тусгай технологиор боловсруулан гаргаж авсан бүтээгдэхүүн бөгөөд олон төрлийн анагаах үндэстэй биологийн идэвхт бүтээгдэхүүн.

ЭРҮҮЛ МЭНДИЙН УС УНДАА ТӨСЛИЙН ЯВЦ

БАРИЛГА:



Үйлдвэрлэлийн дотор засал 65%
Оффисын дотор засал 90%
Агуулахын өргөтгөл 15%

57%

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ:



Савлах шугам 100%
Ус цэвэршүүлэлт 100%
Найрлага 100%
Ургамал хандлагч 100%
Ариутгагч 100%

100%

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



“МОНОС ХҮНС КОМПАНИ “EXPORT MONGOLIA 2019” БИЗНЕС ФОРУМД ОРОЛЦЛОО

“Export Mongolia 2019” бизнес форум хоёрдугаар сарын 28-ны өдөр Corporate Convention Center-ийн Event Hall-д амжилттай зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээний хүрээнд Монос Хүнс компани экспортод гарсан бүтээгдэхүүн болон шинэ бүтээгдэхүүнээ танилцууллаа.



“FOODEX JAPAN 2019” ҮЗЭСГЭЛЭНД “МОНОС ХҮНС” ХХК ОРОЛЦЛОО

Хүнсний салбарын 44 дэх удаагийн “FoodEx 2019” олон улсын үзэсгэлэн Япон улсын Токио хотод энэ оны гуравдугаар сарын 5 - 8-ны хооронд зохион байгуулагдлаа. Уг экспогоор Монос Хүнс компани нь өтгөрүүлсэн барагшун болон чацарганын цэвэр тос бүтээгдэхүүнээ онцлон олон улсад танилцуулсан бөгөөд 2018 оноос Япон улсын зах зээлд экспортлогдоод буй Эко уусдаг цайг амтлуулан бүтээгдэхүүнээ танилцуулав.



“МОНОС ХҮНС” КОМПАНИЙН ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА БОЛЛОО

2019.04.24-ний өдөр Туушин зочид буудалд Монос Хүнс компанийн олон нийтэд зориулсан үнэт цаасны танилцуулга арга хэмжээ зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээнд нийт 500 орчим хүн ирж, хувьцааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч, хувьцааны дансаа нээлгэн, захиалга өгөн, эрүүл мэндийн иж бүрэн зөвлөгөө, шинжилгээнд хамрагдаж оролцсон юм.



“ЭМИЙН МЭРГЭЖИЛТНИЙ М5 ЧУУЛГА УУЛЗАЛТ 2019” АРГА ХЭМЖЭЭ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс компани 05 сарын 9, 10-нд зохион байгуулагдсан энэхүү чуулга уулзалтад Энхжин брэндийн найман нэр төрлийн Тайвшруулах, Дархлаа сэргээх, Уушги хамгаалах, Цэвэрлэх, Бөөр хамгаалах, Элэг хамгаалах, Булцуут цэцгийн, Чихрийн шижингийн эсрэг эрүүл мэндийн цайгаараа ороллоо.



“МОНОС ХҮНС ХК-ИЙН ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА 2019.05.20-НД ЭХЭЛЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо Монос Хүнс компанийн хоёрдогч зах зээлийн арилжааг 2019.05.20-ний өдөр эхлүүлэх зөвшөөрөл олгосон юм.

Монос Хүнс ХК-ийн анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж, татан төвлөрүүлэхээр зорьсон мөнгөн дүнгээс давж биелсэн тул хувь тэнцүүлэн хуваарилалт хийгдсэн.



ЭРҮҮЛ МЭНДЭЭ ДЭМЖИЖ, ИТГЭЛТЭЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙСЭН МОНОС ХҮНС ХК-ИЙН 4004 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭДЭЭ БАЯРЛАЛАА

Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрлэлийн салбарт анхдагч Монос Хүнс компанийн IPO-ийн захиалга Монголын хөрөнгийн биржид 2019.04.22-2019.05.03-ны өдрүүдэд явагдаж, нийт 10.5 тэрбум төгрөг татан төвлөрүүлэн, олон нийтээс захиалга 43 хувиар давж биелсэнээр амжилттай өндөрлөлөө.



МОНОС ХҮНС КОМПАНИ НЬ АЛБАН ЁСООР ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЛОО

Монос Хүнс Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2019 оны 6 дугаар сарын 26-ны өдөр ХолиДэй Инн зочид буудлын хурлын танхимд зохион байгуулагдлаа.



МОНОС ХҮНС КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ АЛБАН ЁСООР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ ЭХЭЛЛЭЭ.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгосон ТУЗ-н гишүүд бүрэн эрхийнхээ хүрээнд үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд компанийн хагас жилийн үйл ажиллагааны тайлантай танилцан хуралдав.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД КОМПАНИЙН “ЭРҮҮЛ МЭНДИЙН УС УНДАА” ТӨСЛИЙН ЯВЦТАЙ ТАНИЛЦЛАА

Монос Хүнс компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар сонгогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүд болох Б.Гантулга, Б.Долгормаа, Ч.Чинзориг нар 2019.07.09-ны өдөр Монос Хүнс компанийн үйл ажиллагаа болон “Эрүүл мэндийн ус ундаа” төслийн явцын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авлаа.



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ШИЛДЭГ ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ, АЖИЛ ОЛГОГЧ БАЙГУУЛЛАГААР МОНОС ХҮНС ХК ТОДОРЛОО

Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс 2019.06.12-ны өдөр “Ажил олгогчдын зөвлөгөөн” арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээний үеэр Хан-Уул дүүргийн “Шилдэг шимтгэл төлөгч ажил олгогч байгууллага”-ыг шалгаруулсан бөгөөд Монос Хүнс ХК шалгарсан юм.

БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ



“ШИДЭТ САРИМС” ХУДАЛДААНД ГАРЛАА

Эх орны хөрсөнд тарьж ургуулсан Монгол саримсыг ашиглан бэлтгэсэн шидэт саримс нь 33-н төрлийн хүхэрт органик нэгдэл, 17 төрлийн амин хүчил, 11 төрлийн эрдэс бодис, 5 төрлийн нүүрс ус, фенолт нэгдлүүдийг тус тус агуулсан байгаль ховор нандин бүтээгдэхүүн юм. Энэхүү бүтээгдэхүүн нь дархлаа дэмжих, холестерин хэмжээг тогтворжуулах, харшлын шинж тэмдэгийг бууруулах, хэт исэлдэлтээс (антиоксидант) урьдчилан сэргийлэх, хавдар үүсгэгч эсийг дарангуйлах зорилгоор хэрэглэнэ.



“ЭНХЖИН” ЭРҮҮЛ МЭНДИЙН ЦАЙ ШИНЭЧЛЭГДЭН ХЭРЭГЛЭГЧДЭД ХҮРЛЭЭ

Эм Судлалын хүрээлэнгийн эрдэмтдийн судалгаанд үндэслэн бүтээгдсэн ЭНХЖИН цуврал цай нь биологийн идэвхт ургамлуудаар нэн баялаг бөгөөд тогтмол хэрэглэснээр аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчилгээний үр дүнг дэмжих үйлчилгээтэй.



“УРТ НАСЛУУЛАХ ГАЗРЫН ДАВИРХАЙ-БАРАГШУН” ХЭРЭГЛЭХЭД ИЛҮҮ ХЯЛБАР САВАЛГААТАЙ БОЛОН ХУДАЛДААНД ГАРЛАА.

Барагшун нь далайн түвшнээс дээш 2500-4000 метрийн өндөр уулын хаданд олон мянган жилийн турш салхи бороо, нарны гэрэл, халуун хүйтэн уур амьсгалын үр дүнд давирхайдан бүрэлдэж тогтсон байгалийн маш ховор биологийн идэвхт түүхий эд юм.

УДИРДЛАГЫН БАГ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Лувсан
ХҮРЭЛБААТАР

ТУЗ-ийн дарга
Монос группийн Ерөнхийлөгч



Хүрэлбаатар
АНАНД

ТУЗ-ийн ердийн гишүүн
Монос групп ХХК
Гүйцэтгэх захирал



Цэдэндэмба
ЦЭЦЭГБАДАМ

ТУЗ-ийн ердийн гишүүн
Монос групп ХХК
Санхүү эрхэлсэн захирал



Агваандорж
ОТГОНДАРЬ

ТУЗ-ийн ердийн гишүүн
Монос Хүнс ХК
Гүйцэтгэх захирал



Хүрэлбаатар
СОЛОНГО

ТУЗ-ийн ердийн гишүүн
Монос косметик ХХК
ТУЗ-ийн дарга



Чимэддорж
БАТТОГТОХ

ТУЗ-ийн ердийн гишүүн
АШУУИС
Тэнхимийн эрхлэгч



Булган
ГАНТУЛГА

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Лэндмин ХК
Гүйцэтгэх захирал



Чулуун
ЧИНЗОРИГ

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Тандем глобал ложистик
Монголиа ХХК
Гүйцэтгэх захирал



Бөхбат
ДОЛГОРМАА

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Голомт фэйнаншил групп ХХК
Санхүү хариуцсан захирал

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Монос Хүнс ХК-ийн Гүйцэтгэх
захирал:

Агваандоржийн
ОТГОНДАРЬ



БОЛОВСРОЛ:

- ХҮДС, Эдийн засагч, Бакалавр /Улаанбаатар, Монгол улс/
- Арван жилийн 2-р дунд сургууль /Булган аймаг, Монгол улс/

АЖЛЫН ТУРШЛАГА:

- Гүйцэтгэх захирал, Монос Хүнс
- Бизнес хөгжлийн захирал, Монос Групп
- Гүйцэтгэх захирал, Алтай Кашмер
- Бизнес Хөгжлийн хэлтсийн дарга, стратеги төлөвлөлтийн менежер, төсөл хөрөнгө оруулалтын менежер, Таван Богд Групп
- Бизнес Хөгжлийн захирал, Монгол Эм Импекс Концерн

ГАВЪЯА, ШАГНАЛ:

- Банк Санхүүгийн салбарын тэргүүний ажилтан-2018, Сангийн Яам
- Үндэсний үйлдвэрлэгч Энтрепренёр хатагтай-2016, МҮХАҮТ
- Хүндэт жуух-2008, МҮХАҮТ

Үйл ажиллагаа хариуцсан
захирал:

Пүрэвсүрэн
ТОДРОЛ



БОЛОВСРОЛ:

- Докуз Эелүл Их Сургууль, Бизнесийн удирдлага, Бакалавр /Измил, Турк улс/

АЖЛЫН ТУРШЛАГА:

- Үйл ажиллагаа хариуцсан захирал, Монос Хүнс
- Санхүүгийн менежер, Монос Хүнс
- Санхүүгийн шинжээч, Энержи Ресурс

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

+24%
 Борлуулалтын орлого
4,610 сая төг

+51%
 EBITDA
1,035 сая төг

ОРЛОГО ҮР ДҮН

ҮЗҮҮЛЭЛТ, САЯ ТӨГРӨГ	2018 Н1	2019 Н1
Борлуулалтын орлого	3,727	4,610
Нийт ашиг /алдагдал/	1,767	2,056
Борлуулалт, маркетинг, түгээлтийн үйл ажиллагааны зардал	811	1,005
Ерөнхий ба удирдлагын зардал	499	745
Нийт үйл ажиллагааны зардал	1,310	1,750
Үйл ажиллагааны ашиг /алдагдал/	457	306
Нийт үйл ажиллагааны бус олз /гарз/	8	82
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	465	388
Орлогын татварын зардал	47	50
Цэвэр ашиг /алдагдал/	418	339
ХТЭХЗӨА /EBITDA/	686	1,035

ЦЭВЭР АШГИЙН МАРЖИН
ЕБИТДА МАРЖИН

11.2%
18.4%


7.3%
22.5%

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

ҮЛДЭГДЭЛ, САЯ ТӨГРӨГ	2018 Н1	2019 Н1
ХӨРӨНГӨ	16,465	22,156
Эргэлтийн хөрөнгө	2,743	10,650
Эргэлтийн бус хөрөнгө	13,722	11,506
Үндсэн хөрөнгө	7,624	7,889
Биет бус хөрөнгө	4,094	3,606
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	16,465	22,156
Өр төлбөр	7,241	4,963
Богино хугацаат өр төлбөр	1,907	1,629
Урт хугацаат өр төлбөр	5,334	3,334
Эздийн өмч	9,224	17,193
Өмч	1,623	2,318
нэмж төлөгдсөн капитал	-	6,849
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	6,985	6,529
Хуримтлагдсан ашиг	615	1,496

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	Зарцуулалт сая, төг
Үйлдвэрийн барилгын өргөтгөл	746
Тоног төхөөрөмж	2,692
Эргэлтийн хөрөнгө	103
Шинэ технологид хөрөнгө оруулалт	236
НИЙТ	3,778

БАЛАНСЫН БҮТЭЦ - 2019 Н1



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
МЭДЭЭЛЭЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Монос Хүнс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2019 оны 6 дугаар сарын 26-ны өдөр ХолиДэй Инн зочид буудлын хурлын танхимд зохион байгуулагдлаа.

Хурлаар дараах дөрвөн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр товлосон байсан юм.

1. Монос Хүнс ХХК-ийн хэлбэрийг өөрчилж Хувьцаат компани болгох;
2. Монос Хүнс ХК-ийн дүрмийг батлах;
3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох;
4. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоох;


Хуульд заасан шаардлагуудыг хангасан тул хурал 14:30-д эхэлж 16:30 гэхэд дууссан бөгөөд хурлаас гарсан шийдвэрийн дагуу Монос Хүнс компани нь албан ёсоор Хувьцаат Компани болон үйл ажиллагаагаа явуулж эхэллээ.

Компанийн үйл ажиллагаа болон шинэ төслийн явцын мэдээллүүдийг хурлыг даргалагч П.Тодрол танилцуулсны дараа Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн 6 гишүүнээр Л.Хүрэлбаатар, Х.Ананд, Х.Солонго, Ц.Цэцэгбадам, А.Отгондарь, Ч.Баттогтох нарыг нэр дэвшүүлж сонгосон бол ТУЗ-ийн хараат бус гишүүнээр нийт 13 хүний анкет танилцуулга ирснээс Б.Гантулга, Б.Долгормаа, Ч.Чинзориг нарыг нэр дэвшүүлэн хувьцаа эзэмшигчдийн саналаар баталгаажуулсан байна.

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Хувьцаа эзэмшигч	Эзлэх хувь
Л. Хүрэлбаатар	70%
Бусад	30%
Нийт	100%

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА



ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

Үзүүлэлт	06-р сарын 30	05-р сарын 20
Гаргасан хувьцааны тоо ширхэг /Ширхэг/	408,850,428	408,850,428
Төрөл	Энгийн хувьцаа	Энгийн хувьцаа
Хувьцааны үнэ		
Хаалтын үнэ	71.1	71.61
Хамгийн их үнэ	72	72
Хамгийн бага үнэ	67	65
Арилжаалагдсан тоо /Ширхэг/	22,300	692,822
Арилжааны үнийн дүн	1,585,530	121,222,983
Компанийн зах зээлийн үнэлгээ /Мянган төгрөг/	26,984,128	29,277,779

НИЙГМИЙН
ХАРИУЦЛАГА



МОНОС ХҮНС КОМПАНИ “БӨӨРӨӨ ХАЙРЛАХ ӨДӨРЛӨГ” ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монос Хүнс компани нийгмийн хариуцлагын хүрээнд "Дэлхийн бөөр хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан "Бөөрөө хайрлах өдөрлөг" арга хэмжээг 2019.03.13-нд Анкор төвд 300 гаруй хүнийг хамруулан амжилттай зохион байгууллаа.



“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ” ӨДӨРЛӨГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Сонгино Хайрхан дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт Монос Хүнс компани нь Мичид ундрага өрхийн эрүүл мэндийн төвийн хамт олонтой хамтран 2019.05.14-ны өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийг дэмжих” өдөрлөгийг амжилттай зохион явууллаа.



МОНОС ХҮНС КОМПАНИ “УЛААНБААТАР МАРАФОН-2019” ТЭМЦЭЭНИЙГ “ЭКОС” ЭРҮҮЛ МЭНДИЙН УСААРАА ИВЭЭН ТЭТГЭЖ ОРОЛЦЛОО.

Бүх нийтээр биеийн тамир, спортыг дэмжих, эрүүл аж төрөх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилго бүхий Олон улсын гүйлтийн тэмцээн 2019.05.18-ний өдөр амжилттай зохион байгуулагдсан бөгөөд Монос Хүнс Компани Экос усаараа ивээн тэтгэж мөн сонирхолтой арга хэмжээнүүдийг санаачлан оролцлоо.




ЭЛЭГНИЙ ЭРҮҮЛ МЭНД ӨДӨРЛӨГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс компани нийгмийн хариуцлагын хүрээнд 2019.05.28-ний 18:00 цагт "Элэгний эрүүл мэнд" өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа.



МОНОС ХҮНС КОМПАНИ "ӨНӨР БҮЛ ХҮҮХДИЙН АСРАМЖИЙН ТӨВ"-ИЙН ХҮҮХДҮҮДЭД ГАРЫН БЭЛЭГ ГАРДУУЛЛАА

Монос Хүнс компани нийгмийн хариуцлагынхаа хүрээнд 2019.05.29-ний өдөр Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Монгол улсын "Өнөр бүл хүүхдийн асрамжийн төв"-ийн хүүхдүүдэд гарын бэлэг гардуулан, хөгжөөнт тоглоом тоглон нэг өдрийг дурсамж дүүрэн өнгөрөөлөө.



РАШААН СУВИЛАЛУУДААР "ЭРҮҮЛ МЭНДИЙН ЦУВРАЛ СУРГАЛТ ӨДӨРЛӨГ" ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монос Хүнс компани нь "Өвөржанчивлан", "Аржанчивлан" "Мойлтын тохой", "Оргил" рашаан сувиллуудаар хэвтэн эмчлүүлж байгаа ахмад буурлууддаа "Эрүүл мэндийн цуврал сургалт өдөрлөг" -үүдийг амжилттай зохион байгууллаа.

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА